

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/014/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhand@audit.gov.mn Аудитор: Г.Энхдэлгэр Утас: 99002291 Цахим хаяг: enkhdelgerg@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

Гурав. Аудитын илрүүлэлт

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 13 № 129

танай _____-ны № _____-т

“АЛТАЙ ХОТЫН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР” АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ Т.ЛОДОЙ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай хотын тохижилт үйлчилгээний газар аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Хязгаарлалттай” санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслийн зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан боловч тендерт шалгараагүй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас 53,836.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн,
- Худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр 64,432.1 мянган төгрөгийн барилгын засварын материал шууд худалдан авалт хийсэн,
- Үндсэн хөрөнгө бүртгэлд авсан барилгын доорх газрыг хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн аваагүй, бүртгэлд тусгаагүй
- Тохижилт үйлчилгээний газруудын баруун бүсийн нөхөрсөг уулзалт, спортын арга хэмжээний оролцооны зардал, ажилчдад биеийн тамирын хувцас хийлгэхэд 8,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

822511000392

Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Алтай хотын тохижилт үйлчилгээний газар аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь Зоонозын өвчин судлалын төвийн хуучин барилгыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын дагуу балансаас балансад шилжүүлж авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Удирдлага буруутай шийдвэр гаргасны улмаас өмнөх онуудад олгосон цалингийн нөхөн олговрын 11,912.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварын 94,252.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсэж бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Есөнбулаг сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 4 зорилт, 20 арга хэмжээний хэрэгжилтийг 96.0 хувиар үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	126,358,324.05	130,829,607.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,378,804.00	890,498.54
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,378,804.00	890,498.54
3121	Төгрөг	5,378,804.00	890,498.54
31213	Арилжааны банк дахь харилцах	5,378,804.00	890,498.54
33	АВЛАГА	42,574,508.71	41,511,273.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	14,949,213.91	13,964,353.60
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
335	Бусад авлага	27,625,294.80	27,546,920.00
3351	Байгууллагаас авах авлага	27,300,000.00	27,300,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	325,294.80	246,920.00
35	БАРАА МАТЕРИАЛ	78,405,011.34	88,427,835.76
351	Түүхий эд материал	4,115,420.00	6,712,100.00
35110	Тусгай зориулалттай материал	4,115,420.00	6,712,100.00
354	Хангамжийн материал	74,289,591.34	81,715,735.76
35410	Бичиг хэргийн материал	208,675.00	183,130.00
35420	Аж ахуйн материал	45,246,266.34	56,534,805.76
35430	Сэлбэг хэрэгсэл	27,497,800.00	24,277,800.00
35440	Түлш, шатах тослох материал	1,023,020.00	720,000.00
35470	Бусад хангамжийн материал	313,830.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,816,028,690.09	8,351,229,303.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,816,028,690.09	8,351,229,303.25
392	Биет хөрөнгө	8,582,164,940.09	8,117,403,053.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,245,788,716.25	1,672,378,959.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	(927,254,404.68)	(225,310,685.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,426,721,716.45	1,466,783,494.57
39204	Хуримтлагдсан элэгдэл	(616,315,672.81)	(590,931,214.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,909,000.00	65,700,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,763,821.88)	(17,526,145.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,295,000.00	6,777,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,690,972.32)	(944,194.86)
39209	Зам, гүүрийн байгууламж	8,479,193,091.18	8,361,923,559.57
39210	Хуримтлагдсан элэгдэл	(3,742,699,647.60)	(4,067,501,026.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,807,193,171.44	2,627,049,549.06
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,120,211,235.94)	(1,180,996,242.48)
393	Биет бус хөрөнгө	233,863,750.00	233,826,250.00
39301	Програм хангамж	4,710,000.00	4,410,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(506,250.00)	(243,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	229,660,000.00	229,660,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,942,387,014.14	8,482,058,911.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	52,400,000.00	146,652,183.87
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	52,400,000.00	146,652,183.87
413	Өглөг	52,400,000.00	146,652,183.87
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	(0.00)	94,252,183.87
4136	Бусад өглөг	52,400,000.00	52,400,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	52,400,000.00	52,400,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,889,987,014.14	8,335,406,727.28
51	Засгийн газрын хувь оролцоо	8,889,987,014.14	8,335,406,727.28

Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,540,074,518.29	4,540,074,518.29
51101	Өмч: - төрийн	4,540,074,518.29	4,540,074,518.29
512	Хуримтлагдсан үр дүн	2,937,025,131.84	2,382,444,844.98
51210	Өмнөх үеийн үр дүн	3,958,528,840.50	2,937,025,131.84
51220	Тайлант үеийн үр дүн	(1,021,503,708.66)	(554,580,286.86)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,412,887,364.01	1,412,887,364.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,942,387,014.14	8,482,058,911.15

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,826,796,691.13	3,273,290,483.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	885,165,452.52	1,027,511,720.20
120	Нийтлэг татварын бус орлого	885,165,452.52	1,027,511,720.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	283,444,177.53	508,375,760.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,105,000.00	3,352,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	259,339,177.53	505,023,760.00
120009	Бусад орлого	3,795,300.00	1,155,500.00
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	94,423.99	172,986.09
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	597,831,551.00	505,392,474.11
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		12,415,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,941,631,238.61	2,245,778,763.67
1330	Төсвийн захирагчдаас	1,941,631,238.61	2,245,778,763.67
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	1,941,631,238.61	2,245,778,763.67
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,805,457,066.48	3,816,995,542.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,805,457,066.48	3,816,995,542.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,790,789,066.48	3,805,377,442.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,083,352,061.00	1,429,977,464.58
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	1,083,352,061.00	1,429,977,464.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	295,860,444.54	365,311,841.27
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	295,860,444.54	365,311,841.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,970,795.46	10,843,257.04
210301	Гэрэл, цахилгаан	136,051,417.41	5,132,279.63
210302	Түлш, халаалт	6,664,870.05	5,626,937.41
210303	Цэвэр, бохир ус	254,508.00	84,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	228,275,821.72	332,878,694.08
210401	Бичиг хэрэг	1,525,825.00	2,635,545.00
210402	Тээвэр, шатахуун	121,426,176.50	111,670,356.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,783,200.00	12,921,662.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	112,553.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,374,867.00	
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	48,417,330.22	53,690,020.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	44,635,870.00	151,961,110.58

Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2105	Нормативт зардал	361,852.00	63,630.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	361,852.00	63,630.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	263,902,018.92	179,170,162.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,800,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,963,800.00	1,064,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,506,497.00	283,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,348,000.00	32,044.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	363,000.00	507,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	682,850.00	403,850.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	82,752.64	80,500.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	16,880,341.00	15,057,862.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	167,689,973.15	23,499,900.00
210816	Татварын байгууллагад төлсөн-ТӨҮГ	68,132,655.13	133,439,806.80
210817	Даатгалын төлбөрт төлсөн-ТӨҮГ	252,150.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,776,066,072.84	1,487,132,392.41
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,776,066,072.84	1,487,132,392.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,668,000.00	11,618,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,668,000.00	11,618,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,460,000.00	6,711,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,208,000.00	4,907,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(978,660,375.35)	(543,705,058.31)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	42,843,333.31	10,875,228.55
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		10,875,228.55
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	42,843,333.31	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(42,843,333.31)	(10,875,228.55)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,021,503,708.66)	(554,580,286.86)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,969,625,962.60	2,250,459,249.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,889,723.99	4,680,486.09
120	Нийтлэг татварын бус орлого	3,889,723.99	4,680,486.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,352,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,352,000.00
120009	Бусад орлого	3,795,300.00	1,155,500.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	94,423.99	172,986.09
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,965,736,238.61	2,245,778,763.67
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,105,000.00	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	24,105,000.00	
1330	Төсвийн захирагчдаас	1,941,631,238.61	2,245,778,763.67
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	1,940,431,238.61	2,245,778,763.67

Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	1,200,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,001,767,494.42	2,254,947,555.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,001,767,494.42	2,254,947,555.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,987,217,494.42	2,239,309,455.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,068,411,688.00	1,373,342,877.20
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	1,068,411,688.00	1,373,342,877.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	325,665,947.16	351,633,313.68
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	325,665,947.16	351,633,313.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,970,795.46	10,843,257.04
210301	Гэрэл, цахилгаан	135,607,092.74	5,132,279.63
210302	Түлш, халаалт	7,109,194.72	5,626,937.41
210303	Цэвэр, бохир ус	254,508.00	84,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	212,110,519.50	317,727,085.50
210401	Бичиг хэрэг	1,527,500.00	2,610,000.00
210402	Тээвэр, шатахуун	121,426,176.50	111,670,356.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,783,200.00	12,921,662.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,435,000.00	
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	41,680,173.00	69,103,600.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	36,258,470.00	121,421,467.00
2105	Нормативт зардал	4,721,300.00	20,141,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	506,300.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,215,000.00	20,141,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,154,000.00	4,792,000.00
210602	Тавилга	-	4,792,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,154,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	224,183,244.30	160,829,821.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,950,000.00	4,800,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,963,800.00	1,064,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,506,497.00	283,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,491,000.00	32,044.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	462,000.00	507,500.00
210807	Газрын төлбөр	682,850.00	682,850.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	82,752.64	80,500.00
210813	Бусад зардал-ТӨҮГ	101,163,695.00	
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	107,628,499.66	121,620,867.80
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	252,150.00	
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/		31,757,360.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,550,000.00	15,638,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,550,000.00	15,638,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,342,000.00	10,731,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,208,000.00	4,907,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(32,141,531.82)	(4,488,305.46)

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(32,141,531.82)	(4,488,305.46)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,520,335.82	5,378,804.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,378,804.00	890,498.54

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөг)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,540,074,518.29	1,412,887,364.01	2,937,025,131.84	8,889,987,014.14
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,540,074,518.29	1,412,887,364.01	2,937,025,131.84	8,889,987,014.14
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,540,074,518.29	1,412,887,364.01	2,937,025,131.84	8,889,987,014.14
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,540,074,518.29	1,412,887,364.01	2,937,025,131.84	8,889,987,014.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,540,074,518.29	1,412,887,364.01	2,937,025,131.84	8,889,987,014.14
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(554,580,286.86)	(554,580,286.86)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,540,074,518.29	1,412,887,364.01	2,382,444,844.98	8,335,406,727.28

2.5 Зорилтот түвшин, гүйцэтгэл (төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,329,688,566.7	2,254,947,555.2	74,741,011.50	96.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,329,688,566.7	2,254,947,555.2	74,741,011.5	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,296,820,566.7	2,239,309,455.22	57,511,111.5	97.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,443,309,360.0	1,373,342,877.20	69,966,482.8	95.2
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	1,443,309,360.0	1,373,342,877.20	69,966,482.8	95.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	428,669,152.0	351,633,313.68	77,035,838.3	82.0
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	428,669,152.0	351,633,313.68	77,035,838.3	82.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,779,354.7	10,843,257.04	936,097.7	92.1
210301	Гэрэл, цахилгаан	4,620,000.0	5,132,279.63	(512,279.6)	111.1

Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

210302	Түлш, халаалт	7,109,194.7	5,626,937.41	1,482,257.3	79.2
210303	Цэвэр, бохир ус	50,160.0	84,040.00	(33,880.0)	167.5
2104	Хангамж, бараа материалын зардал	242,317,300.0	317,727,085.50	(75,409,785.5)	131.1
210401	Бичиг хэрэг	875,000.0	2,610,000.00	(1,735,000.0)	298.3
210402	Тээвэр, шатахуун	140,160,000.0	111,670,356.50	28,489,643.5	79.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,040,000.0	12,921,662.00	7,118,338.0	64.5
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	46,058,000.0	69,103,600.00	(23,045,600.0)	150.0
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	35,184,300.0	121,421,467.00	(86,237,167.0)	345.1
2105	Нормативт зардал	4,320,000.0	20,141,100.00	(15,821,100.0)	466.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,320,000.0	20,141,100.00	(15,821,100.0)	466.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,500,000.0	4,792,000.00	14,708,000.0	24.6
210602	Тавилга	-	4,792,000.00	(4,792,000.0)	
210604	Урсгал засвар	19,500,000.0	-	19,500,000.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146,925,400.0	160,829,821.80	(13,904,421.8)	109.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,800,750.00	(4,800,750.0)	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,064,000.00	(1,064,000.0)	
210803	Даатгалын үйлчилгээ	1,600,000.0	283,950.00	1,316,050.0	17.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,500,000.0	32,044.00	1,467,956.0	2.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	462,000.0	507,500.00	(45,500.0)	109.8
210807	Газрын төлбөр	780,600.0	682,850.00	97,750.0	87.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	82,800.0	80,500.00	2,300.0	97.2
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	127,500,000.0	121,620,867.80	5,879,132.2	95.4
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	15,000,000.0	31,757,360.00	(16,757,360.0)	211.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,868,000.00	15,638,100.00	17,229,900.00	47.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,868,000.0	15,638,100.00	17,229,900.0	47.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,873,000.0	4,907,100.00	20,965,900.0	19.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,107,130,701.4	2,250,459,249.76	(143,328,548.4)	106.8
1330	Төсвийн захирагчдаас	2,107,130,701.4	2,245,778,763.67	(138,648,062.3)	106.6
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	2,107,130,701.4	2,245,778,763.67	(138,648,062.3)	106.6
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,680,486.09	(4,680,486.1)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,352,000.00	(3,352,000.0)	
120009	Бусад орлого		1,155,500.00	(1,155,500.0)	

120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/		172,986.09	(172,986.1)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,378,804.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	890,498.54		

Гурав. Аудитын илрүүлэлт

3.1 Аудитаар 55,124.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Тайлант үеийн үр дүнг 55,124.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Залруулагдаагүй нийт 126,268.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 126,268.3 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрч зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлсэн.

3.2 Албан шаардлага

1. Ажилчдад биеийн тамирын хувцас хийлгэж 4,000.0 мянган төгрөгийг байгууллагаас төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйдийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг: Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой

Илрүүлэлт: Тохижилт үйлчилгээний газруудын баруун бүсийн нөхөрсөг уулзалт, спортын арга хэмжээний оролцооны зардалд 4,000.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнд төсөв хөрөнгө зарцуулахгүй байх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хоёр: Худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт: Түлш шатахуун, сэлбэг хэрэгслийн зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан боловч тендерт шалгараагүй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас 53,836.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тендерт шалгарсан иргэн, аж ахуй нэгж байгууллагаас худалдан авалт хийж байх

Гурав: Худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр 64,432.1 мянган төгрөгийн барилгын засварын материал шууд худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Босго үнээс давсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

Дөрөв: Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй барилгын доорх газрыг шилжүүлэн аваагүй, бүртгэлд тусгаагүй байгаа нь Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3-т "Газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс үл хөдлөх эд хөрөнгөд хамаарна". Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т " Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага заавал бүртгэнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Барилгын доорх газрыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлж, бүртгэлд тусгах арга хэмжээг авах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруула агүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ	Тайлант үеийн үр дүнг 55,124.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	55,124.6	-	-	1	55,124.6	1	55,124.6				
Дүн		1	55,124.6	-	-	1	55,124.6	1	55,124.6	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ	Ажилчдад биеийн тамирын хувцас хийлгэж 4,000.0 мянган төгрөгийг байгууллагаас төлсөн.	1	4,000.0	-	-	1	4,000.0			-	-
	Тохижилт үйлчилгээний газруудын баруун бүсийн нөхөрсөг уулзалт, спортын арга хэмжээний оролцооны зардалд 4,000.0 мянган төгрөг зарцуулсан.	1	4,000.0	-	-	-	-	1	4,000.0	-	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслийн зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан боловч тендерт шалгараагүй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас 53,836.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн.	1	53,836.2	-	-	-	-	1	53,836.2	-	-
	Худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр 64,432.1 мянган төгрөгийн барилгын засварын материал шууд худалдан авалт хийсэн байна.	1	64,432.1	-	-	-	-	1	64,432.1	-	-
	Үндсэн хөрөнгө бүртгэлд авсан барилгын доорх газрыг хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн аваагүй, бүртгэлд тусгаагүй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-
Нийт		5	126,268.3	-	-	1	4,000.0	4	122,268.3	-	-